

## **ТӨЛБӨРИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЖУРАМ**

### **Нэг. Ерөнхий нөхцөл**

- 1.1. Энэ журмын зорилго нь “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид “ҮЦТХТ” гэх/ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу арилжааны төлбөрийн үйл ажиллагаа /цаашид “төлбөрийн үйлчилгээ” гэх/ үзүүлэхтэй холбогдон учирч болох эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг буруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү харилцаанд Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, тогтоомж болон “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн зүгээс гаргасан Эрсдэлийн сангийн журам болон бусад журмыг удирдлага болгоно.
- 1.3. Энэхүү журамд тусгагдаагүй, харилцааг холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу зохицуулна.

### **Хоёр. Журмын нэр томьёо**

- 2.1. “Төлбөр” гэж “ҮЦТХТ” нь үнэт цаасыг шилжүүлэх болон түүний төлбөрийг эцэслэн гүйцэтгэх үйл явцыг;
- 2.2. “Эрсдэл” гэж “ҮЦТХТ” ХХК-д арилжааны төлбөр гүйцэтгэхтэй холбоотой учирч болох дараах эрсдэлийг ойлгоно.
  - 2.2.1. Төлбөр хугацаандаа орж ирэхгүй байх буюу саатал бий болох;
  - 2.2.2. Төлбөр гүйцэтгэх системд төлбөрийн үйлчилгээ үзүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх;
  - 2.2.3. Гэнэтийн болон байгалийн давагдашгүй хүчин зүйлээс үүдэн эрсдэл үүсэх;
  - 2.2.4. Төлбөр гүйцэтгэх этгээдийн ёс зүйн зөрчил үүсэх;
  - 2.2.5. Бусад эрсдэлийг ойлгоно.

### **Гурав. Эрсдэлийн удирдлагын алба**

- 3.1. Төлбөрийн үйлчилгээний байгууллага нь төлбөрийн үйлчилгээнд гарч болох эрсдэлийг тодорхойлох эрсдэлийн удирдлагын албатай байна.
- 3.2. Эрсдэлийн удирдлагын алба нь үнэт цаасны зах зээлийн арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэхэд учирч болох эрсдэлийг үнэлэх, эрсдэлийг удирдах дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 3.2.1. Төлбөрийн үйл ажиллагаанд учирч болох /зах зээлийн эрсдэл, төлбөрийн чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл/ эрсдэлийн удирдлага, бодлогыг боловсруулж мөрдөх;

### **Дөрөв. Эрсдэл бий болсон үед авах арга хэмжээ**

- 4.1. Журмын 2.2-д заасан эрсдэл үүссэн үед дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
- 4.2. Төлбөр хугацаандаа орж ирэхгүй байх буюу мөнгөн төлбөрийн саатал гарсан тохиолдолд энэ талаар Клирингийн төвд нэн даруй мэдэгдэнэ.
- 4.2.1. Клирингийн төв саатсан төлбөрийг өөрийн зөвшөөрөгдсөн хөрөнгийн эх үүсвэр /төлбөрийн баталгааны сан/-ээр гүйцэтгэж эрсдэлийг бүрэн хаана.
- 4.3. Системийн ачаалал, доголдлын улмаас төлбөр гүйцэтгэх боломжгүй болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс Мэдээлэл, технологийн алба нь улирал бүр тест хийж системийн доголдлоос урьдчилан сэргийлж байх.
- 4.3.1. Системийн доголдол бий болж төлбөрийг гүйцэтгээгүй тохиолдолд клирингийн төв болон төлбөрийн гишүүдэд нэн даруй мэдэгдэнэ
- 4.3.2. Системийн доголдлын шалтгааныг илрүүлж яаралтай авах арга хэмжээг тодорхойлно.
- 4.4. Монгол банкны системээр төлбөрийг гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүсвэл аль нэг арилжааны банкиг төлбөр гүйцэтгэх банкаар сонгож системийг хэвийн байдалд орох хүртэл төлбөр гүйцэтгэнэ.

### **Тав. Эрсдэлийн үнэлгээ**

- 5.1. Төлбөрийн үйлчилгээтэй холбоотой ажил эрхэлж буй ажилтан нь аюул эрсдэлийг тодорхойлсон даруйдаа холбогдох албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ
- 5.2. Учирч болзошгүй эрсдэлийг тооцоолох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийдэг мэргэжлийн байгууллагаар эрсдэлийн үнэлгээ хийлгэж болно.

### **Зургаа. Эрсдэлийн сан**

- 6.1. Төлбөрийн үйлчилгээнээс системд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор “ҮЦТХТ” нь эрсдэлийн санг байгуулна.
- 6.2. “ҮЦТХТ” нь эрсдэлээс хамгаалах сангийн эх үүсвэр нь компанийн санхүүгийн тайлангийн тайлант үеийн цэвэр ашгаас хуваарилагдсан байна.
- 6.3. Эрсдэлийн санг тухайн санхүүгийн тайлангийн тайлант үеийн цэвэр ашгийн 5 хувьтай тэнцүү хэмжээгээр тооцон бүрдүүлнэ.

### **Долоо. Хяналт шалгалт.**

7.1 Төлбөрийн үйл ажиллагааны эрсдэлийг төлбөр гүйцэтгэж байгаа ажилтан болон клирингийн төв Мэдээллийн технологи, дотоод хяналт хариуцсан алба/нэгж хянана.

### **Найм. Хариуцлага.**

8.1 Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

8.2 Энэхүү журмыг зөрчсөн нь Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

--oOo--